



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 5/13

Хэрлэнбаян-Улаан тосгон

Ажлын байр сэлгэн ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 зүйлийн 47.1, 59 зүйлийн 59.1.1 дахь Засгийн газрын 2018 оны 12 сарын 19-ний өдрийн 382-р тогтоолын 1 дахь хавсралт, 2024 оны 12 сарын 25-ны өдрийн 228-р тогтоол болон ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ээлжийн сувилагч Ренчиндорж овогтой Даваасүрэн нь тархины цус хомсдол, харвалтын дараах баруун гар хөлийн хөнгөн саа оноштойгоор ээлжийн ажил хийх боломжгүй болсон тул 2025 оны 7 сарын 8-ны өдрөөс эхлэн өдрийн 8 цагийн ажил олгож нийгмийн эрүүл мэндийн ажилтнаар томилсугай.

2.Р.Даваасүрэнг үндсэн цалинг ТҮЭМ-3 зэрэглэлээр тогтоон 1347000(Нэг сая гурван зуун дөчин долоон мянга) төгрөгөөр цалинжуулж, хоол унааны нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, орон нутгийн нэмэгдэл, илүү цагийн хөлс, төрийн албанд ажилласан жилийн нэмэгдлийг зохих хувиар тооцож цалинжуулахыг нягтлан бодогч (Ю.Батбаяр)-д даалгасугай.

ЭРХЛЭГЧ  Н.МӨНХТУЯА

